



## МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Метро бизнес төв, А блок 5 давхар  
Д.Сүхбаатарын гудамж-13  
Сүхбаатар дүүрэг, УБ 14201-0033  
Утас: 30 42 58, Факс: (976-11) 32 77 20  
Цахим хуудас: [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn)  
Цахим шуудан: [info@crc.gov.mn](mailto:info@crc.gov.mn)

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗАРТ,  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

2024.08.19 № 01/1577  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх тухай

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад Үндэсний аудитын газраас санхүүгийн тайлангийн аудит хийж менежментийн захидлаар нийт гурван зөвлөмж, дөрвөн албан шаардлагыг ирүүлсэн.

Тус зөвлөмжийн хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2024 оны 8 дугаар сарын 16-ны байдлаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

Үүнд:

### Зөвлөмж 1 ажлын хүрээнд:

Утга: Дансны авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

Тусгай зөвшөөрлийн авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Гэрээнд заасан тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх хугацаа хэтэрсэн 400 гаран зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалтыг шүүн гаргаж сонсох ажиллагаа бүхий 04/384 тоот бүхий албан мэдэгдлийг нэхэмжлэхийн хамт хүргүүлж ажилласан.
- Тус хорооны зөвшөөрлийн төлбөр тооцоолдог "bill.crc.gov.mn" системээс зөвшөөрөл эзэмшигчдэд төлбөрийн нэхэмжлэх имэйл хаягт, мэдэгдэл утасны дугаар руу тухай бүр автоматаар илгээгдэж байгаа болно.
- Хуулийн зөвлөгөө үзүүлдэг фирмүүдтэй авлага барагдуулах тухай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.
- Монгол Банкны зээлийн мэдээллийн санд өр төлбөртэй хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийг нийлүүлэхээр ажиллаж байна.
- 2023 оны жилийн эцсээр тайлагнагдсан 4,896.3 сая төгрөгийн авлагаас өссөн дүнгээр 647.9 сая төгрөгийн авлага барагдаж, Жимобайл ХХК-д холбогдох Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх магадлал 210/МА2024/01059 шийдвэр гарсан бөгөөд нийт 1.448.8 сая төгрөгөөс 1.215.9 сая төгрөгийг ХХЗХ-д төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарч баталгаажин ирсэн.

### Зөвлөмж 2 ажлын хүрээнд:

Утга: Дансны өглөг, өр төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХХОАТатварын өглөг, НДШ-ийн өглөгтэй гарсныг 2024 оны 1-р сард төлж барагдуулсан.

### Зөвлөмж 3 ажлын хүрээнд:

Утга: Шилэн дансны бүртгэл

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээг хуулинд тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж ажиллаж байна.

**Зөрчил арилгах тухай албан шаардлага:**

1. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, эрсдэлийг оновчтой тодорхойлон үр дүнтэй аудитыг хийж гүйцэтгэх:

2024 оны Дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд "ХХЗХ-ны санхүүгийн үйл ажиллагааны үр ашигтай байдалд үнэлгээ хийх, дүгнэлт тайлан танилцуулах" ажлыг төлөвлөсөн бөгөөд шинжилгээг дараах 3 чиглэлээр хийж байна. Үүнд:

- ХХЗХ-ны санхүүжилт, орлого төвлөрүүлэх журам (Ойлголт болон Шинжилгээ)
- Төсөвлөлт, зардлын үр ашигтай байдал (Ойлголт болон Шинжилгээ)
- Зохицуулалтын үйл ажиллагааны үр нөлөө (RIA, Regulatory Impact Assessment)-г хэмжих, тайлагнах

Орлого болон Зохицуулалтын үйл ажиллагааны үр нөлөө хэмжих хэсгийн дэд дүгнэлт гарсан бөгөөд Зардлын үр ашигтай байдал хэсгийг 2024 оны 9 дүгээр сарын 15-ны дотор байгууллагын удирдлагад тайлагнахаар ажиллаж байна.

2.3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах

ХХЗХорооны хуралдааны 2023 оны 155 тоот тогтоолоор 2024 онд нийт 2,586.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг баталснаас 800.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Худалдан авах ажиллагаанд тусгагдсан 18 тендерийг tender.gov.mn-д давхардсан тоогоор 24 удаа зарласан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 68 төсөл арга хэмжээнээс гэрээ дүгнэж дууссан 26, гэрээ байгуулсан 25, гэрээ байгуулах шатанд 1, үнэлгээ хийх шат 0, зарласан 0, Үнэлгээний хороо байгуулагдсан 2, үлдсэн 14 байна. Тендертэй холбоотой гомдол маргаан гараагүй. Худалдан авах ажиллагааг төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн хяналтыг тогтмол хийн ажиллаж байна.


4. Төрийн албаны тухай хуулийг мөрдлөг болгон ажиллах

Хорооны даргын 2024.04.30-ны өдрийн А/130 тоот тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам, Харилцаа холбооны зохицуулах хорооны ажилтан, албан хаагчдын улирлын ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, ажлын үр дүнгээр урамшуулал олгох журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх санал боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Тухайн ажлын хэсэг 2024.05.03 А/152 тоот тушаалаар "Харилцаа холбооны зохицуулах хорооны ажилтан, албан хаагчдын улирлын ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, ажлын үр дүнгээр урамшуулал олгох журам"-д өөрчлөлт оруулж шинэчлэн батлуулсан.

Холбогдох баримтыг хавсаргав.

Хавсралт: 11 хуудастай.

ДАРГА



Г.ЧИНЗОРИГ